

**ГОВЬ ХК-ИЙН 2023 ОНЫ 3-Р УЛИРЛЫН
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН**

Хагас жил, улирлын үйл ажиллагааны тайлан /маягт 2/																			
Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 20 дугаар зүйлд Үнэт цаас гаргагчийн нийтлэг үүргийг хуульчилсан бөгөөд үнэт цаас гаргагч нь жилийн үйл ажиллагааны тайлан дараах маягтын дагуу Санхүүгийн зохицуулах хороо, арилжаа эрхлэх байгууллагад мэдээлэл ирүүлж, өөрийн цахим хуудсаар дамжуулан олон нийтэд мэдээлэл хүргэх үүрэгтэй.																			
Тайлагнах хугацаа	2023 оны 01-р сарын 01-ний өдрөөс 2023 оны 09-р сарын 30-ны өдөр																		
Үнэт цаас гаргагчийн нэр, улсын бүртгэлийн гэрчилгээний дугаар, үнэт цаасны код, утасны дугаар	Компанийн нэр: “Говь” ХК УБГД: 9010001061 Үнэт цаасны код: MN00GOV03548 Албан ёсны хаяг: Монгол улс, Улаанбаатар хот-17062, Хан-Уул дүүрэг, 3-р хороо, Үйлдвэрийн гудамж, Говь ХК Утасны дугаар: (+976) 7013-9977 Факс: (976)-70143081 И-мэйл: info@gobi.mn Веб сайт: info.gobi.mn Фейсбүүк: GobiCashmere Онлайн дэлгүүр: Монгол: gobi.mn Европ: gobicashmere.com Америк: gobicashmere.com/us Их Британи: gobicashmere.com/uk Хятад: gobicashmere.cn																		
Бүртгэлтэй арилжаа эрхлэх байгууллагын нэр	Монголын Хөрөнгийн Бирж																		
Бизнесийн үйл ажиллагааны салбар	Ямааны ноолуурт цогц боловсруулалт хийж, бүтээгдэхүүн үйлдвэрлэн борлуулах																		
Үнэт цаас гаргагчийн гаргасан нийт хувьцааны тоо ширхэг	780,112,500																		
Хагас жил, улирлын тайланг бэлтгэсэн мэргэжилтэн, хянасан албан тушаалтны нэр	Улирлын тайланг бэлтгэсэн мэргэжилтэн: М.Сэлэнгэ /ТУЗ-ийн нарийн бичгийн дарга/ Хянасан: Б.Энхмандах /Тэргүүн дэд захирал/																		
1.	Хагас жилийн болон улирлын санхүүгийн тайлан /хураангуй тайлангийн үзүүлэлтийг бөглөж, санхүүгийн тайланг хавсаргана/																		
1.1.	Санхүүгийн байдлын үзүүлэлт																		
	<table border="1"> <thead> <tr> <th>Хөрөнгө</th> <th>Дүн</th> </tr> </thead> <tbody> <tr> <td>Эргэлтийн хөрөнгө</td> <td>204,544,877</td> </tr> <tr> <td>Эргэлтийн бус хөрөнгө</td> <td>150,435,632</td> </tr> <tr> <td>Нийт хөрөнгийн дүн</td> <td>354,980,509</td> </tr> <tr> <td>Богино хугацаат өр төлбөр</td> <td>229,595,235</td> </tr> <tr> <td>Урт хугацаат өр төлбөр</td> <td>120,222,072</td> </tr> <tr> <td>Нийт өр төлбөрийн дүн</td> <td>349,817,308</td> </tr> <tr> <td>Эзэмшигчдийн өмч</td> <td>5,163,202</td> </tr> <tr> <td>Нийт өр төлбөр ба эзэмшигчдийн өмчийн дүн</td> <td>354,980,509</td> </tr> </tbody> </table>	Хөрөнгө	Дүн	Эргэлтийн хөрөнгө	204,544,877	Эргэлтийн бус хөрөнгө	150,435,632	Нийт хөрөнгийн дүн	354,980,509	Богино хугацаат өр төлбөр	229,595,235	Урт хугацаат өр төлбөр	120,222,072	Нийт өр төлбөрийн дүн	349,817,308	Эзэмшигчдийн өмч	5,163,202	Нийт өр төлбөр ба эзэмшигчдийн өмчийн дүн	354,980,509
Хөрөнгө	Дүн																		
Эргэлтийн хөрөнгө	204,544,877																		
Эргэлтийн бус хөрөнгө	150,435,632																		
Нийт хөрөнгийн дүн	354,980,509																		
Богино хугацаат өр төлбөр	229,595,235																		
Урт хугацаат өр төлбөр	120,222,072																		
Нийт өр төлбөрийн дүн	349,817,308																		
Эзэмшигчдийн өмч	5,163,202																		
Нийт өр төлбөр ба эзэмшигчдийн өмчийн дүн	354,980,509																		

1.2.	Орлогын тайлан	Орлогын тайлан	Дүн																		
		Борлуулалтын орлого	166,375,788																		
		Тайлант жилийн цэвэр алдагдал	(3,883,472)																		
1.3.	Өмчийн өөрчлөлтийн тайлан	Өмчийн өөрчлөлтийн тайлан																			
		Эзэмшигчдийн өмч	5,163,202																		
1.4.	Мөнгөн гүйлгээний тайлан	Мөнгөн гүйлгээний тайлан																			
		Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	4,760,961																		
3-р улирлын санхүүгийн нэгтгэсэн тайланг хавсаргав. /Хавсралт-1/																					
2.	Хагас жилийн болон улирлын санхүүгийн тайланг хэлэлцэж, баталгаажуулсан төлөөлөн удирдах зөвлөлийн дэргэдэх Эрсдэл, аудитын хорооны дүгнэлт																				
Эрсдэл, аудитын хорооны шийдвэрийг хамт хавсаргав. /Хавсралт-2/																					
3.	Тайлант хугацаанд үнэт цаас гаргагчийн санхүүгийн үйл ажиллагаанд нөлөөлсөн гадаад, дотоод хүчин зүйлс, санхүүгийн тайлангийн шинжилгээ, орлого, зарлага, ашигийн үзүүлэлтүүдийг тооцож дүгнэсэн удирдлагын тайлан, дүгнэлт																				
3.1.	Үйл ажиллагааны үр дүн /санхүүгийн харьцааны үзүүлэлтүүд/	<table border="1"> <thead> <tr> <th>Үзүүлэлт</th> <th>2022.09.30</th> <th>2023.09.30</th> </tr> </thead> <tbody> <tr> <td>Бохир ашгийн маржин</td> <td>47%</td> <td>48%</td> </tr> <tr> <td>Цэвэр ашгийн маржин</td> <td>-13%</td> <td>-2%</td> </tr> <tr> <td>Эргэлтийн харьцаа</td> <td>1.0</td> <td>0.9</td> </tr> <tr> <td>Бараа материалын эргэц</td> <td>590</td> <td>436</td> </tr> <tr> <td>Хувьцааны нэгж үнэ /₮/</td> <td>265</td> <td>297</td> </tr> </tbody> </table>		Үзүүлэлт	2022.09.30	2023.09.30	Бохир ашгийн маржин	47%	48%	Цэвэр ашгийн маржин	-13%	-2%	Эргэлтийн харьцаа	1.0	0.9	Бараа материалын эргэц	590	436	Хувьцааны нэгж үнэ /₮/	265	297
Үзүүлэлт	2022.09.30	2023.09.30																			
Бохир ашгийн маржин	47%	48%																			
Цэвэр ашгийн маржин	-13%	-2%																			
Эргэлтийн харьцаа	1.0	0.9																			
Бараа материалын эргэц	590	436																			
Хувьцааны нэгж үнэ /₮/	265	297																			
3.2.	Хөрвөх чадвар болон санхүүгийн нөөц, боломжийн үзүүлэлт																				
3.3.	Үнэт цаас гаргагчийн үйл ажиллагаанд гадаад, дотоод орчны нөлөөлөл, бүтээгдэхүүн, үйлчилгээний төрөл хэлбэрт гарч буй өөрчлөлт, дээрх өөрчлөлтөд компанийн зүгээс авч хэрэгжүүлж буй арга хэмжээний мэдээлэл	<ul style="list-style-type: none"> Цар тахлын нөлөөлөл буурч, дэлхий даяар аялал жуулчлалын салбар сэргэж эхэлсэн, Хятад улс хилээ нээсэн зэрэг гадаад орчны нөхцөл байдал өнгөрсөн онтой харьцуулахад сайжирсан нь компанийн дотоод болон гадаад зах зээлийн борлуулалтад эерэг нөлөөтэй байна. Монгол улсын засгийн газраас 1 сая жуулчин хүлээн авах зорилт дэвшүүлэн аялал жуулчлалын салбарыг хөгжүүлэх бодлого баримтлан ажиллаж байгаагийн үр дүнд Монгол улсад ирэх жуулчдын тоо өмнөх жилүүдээс нэмэгдсээр байна. Иймд манай компанийн дотоод борлуулалтын газрын зүгээс 4-р сард аялал жуулчлалын улирлын нээлтийг зохион байгуулж Аялал жуулчлалын холбоо, аяллын байгууллагууд болон хөтөч жолооч нартай хамтран ажиллаж дотоод зах зээлийн борлуулалтыг нэмэгдүүлэхэд анхаарч ажиллаж байна. 2023 оны 3-р улирлын байдлаар дотоодын зах зээлийн борлуулалт өнгөрсөн оны мөн үеэс 88%-иар өссөн. Говь брэндийн Монгол ноолууран бүтээгдэхүүнийг дэлхийн зах зээлд таниулах зорилгын хүрээнд олон улсад гадаад борлуулалтын сувгуудаа сайжруулж, 9 хэл дээр вебсайт ашиглалтад оруулж, маркетинг идэвхжүүлэлтийн ажлуудыг хийсний үр дүнд Говь брэндийн танигдалт нэмэгдсээр байгаа бөгөөд шинэ харилцагчийг татах зардал өнгөрсөн оноос 4.3 дахин буурч, бүртгэлтэй харилцагчдын тоо 3.3 дахин өссөн. Харин борлуулалтын орлогын хувьд 2023 оны 3-р улирлын байдлаар өмнөх оны мөн үетэй харьцуулахад Европ, АНУ, Хятадын зах зээл дээр 13%, 58%, 17% -иар тус тус өссөн үзүүлэлттэй байна. Бүтээгдэхүүний загвар дизайнаа дэлхийд өрсөлдөхүйц түвшинд хүргэх зорилгоор Говь брэндийн ерөнхий 																			

		<p>дизайнераар Италийн алдарт загвар зохион бүтээгч Giorgio Spina ажиллаж эхэлсэн бөгөөд 6-р сард дэлхийн хэмжээний загварын шоуг Монголдоо зохион байгуулж анхны коллекцуудаа амжилттай танилцуулан, бүтээгдэхүүнээ худалдаанд гаргасан. Тус коллекцийн борлуулалт 6-9 сарын дотоодын борлуулалтын орлогын 19%-ийг бүрдүүлээд байна.</p> <ul style="list-style-type: none"> Говь брэнд бүтээгдэхүүний нэр төрлөө нэмэгдүүлж тусгай аргаар боловсруулсан нягт өндөртэй шинэ төрлийн 100% ноолууран Felton материалыг гарган ноолууран бүтээгдэхүүн хөгжлийг нэг шатаар ахиулсан Монголдоо анхдагч ноолууран гутлыг хөгжүүлэн дотоодын хэрэглэгчдэд хүргэсэн. Гадаад борлуулалтын сувгаа нэмэгдүүлэн 9-р сард Бүгд Найрамдах Казахстан Улсад охин компаниа байгуулсан. 					
3.4.	Санхүүгийн байдлын тайлангийн гадуур бүртгэгдсэн ажил, гүйлгээний талаарх дэлгэрэнгүй мэдээлэл, нягтлан бодох бүртгэлийн бодлого	Санхүүгийн байдлын гадуур бүртгэгдсэн ажил, гүйлгээ байхгүй.					
4.	Үнэт цаас гаргагчийн тайлант хугацаанд хийгдсэн сонирхлын зөрчилтэй хэлцэл болон их хэмжээний хэлцлийн мэдээлэл, хэлцэл хийгдэх ач холбогдол зорилго, сонирхлын зөрчилтэй этгээдийн талаарх мэдээлэл /тайлант хугацаанд хийгдсэн нийт сонирхлын зөрчилтэй хэлцлийн талаарх мэдээллийг тусгана/						
ИХ ХЭМЖЭЭНИЙ ХЭЛЦЭЛ							
(мян.төг)							
Огноо	Гэрээ хэлцлийн утга	Үнийн дүн	Гэрээний нөгөө тал	Гэрээний нөхцөл, болзол	Эхлэх огноо	Дуусах огноо	Хэлцэл баталсан
2023.04.14	Хас банкнаас зээл авах	25,000,000	Хас Банк	Ноолуур бэлтгэлийн хүүгийн хөнгөлөлттэй зээл	2023.04.14	2024.04.01	ТУЗ-ийн тогтоол №13
2023.05.26	"Ариг Банк" ХХК-аас зээл авах	14,500,000	"Ариг Банк" ХХК	Ноолуур бэлтгэлийн хүүгийн хөнгөлөлттэй зээл	2023.05.29	2024.05.30	ТУЗ-ийн тогтоол №18
СОНИРХЛЫН ЗӨРЧИЛТЭЙ ХЭЛЦЭЛ							
Огноо	Гэрээ хэлцлийн утга	Үнийн дүн	Гэрээний нөгөө тал	Гэрээний нөхцөл, болзол	Эхлэх огноо	Дуусах огноо	Хэлцэл баталсан
2023.06.16	Хаан банкны зээлийн эрх нээх гэрээнд нэмэлт өөрчлөлт оруулах	10.0 тэрбум төгрөг	Хаан Банк	Ноолуур бэлтгэлийн хүүгийн хөнгөлөлттэй зээл	2023.06.28	2024.06.05	ТУЗ-ийн тогтоол №20
2023.09.22	Гэрээ байгуулах зөвшөөрөл олгох	400.0 мянган ам.доллар	Говь Кашмер Казахстан (охин компани)	Худалдах, худалдан авах гэрээ байгуулах	2023.09.26	2023.12.31	ТУЗ-ийн тогтоол №33

ХОЛБООТОЙ ТАЛУУДАЙ ХИЙСЭН ГҮЙЛГЭЭ

(мян.төг)

Холбоотой талуудтай хийсэн гүйлгээ	2022.09.30	2023.09.30
Холбоотой талд өгсөн санхүүжилт	105,970,741	201,880,000
Холбоотой талаас авсан санхүүжилт	105,970,741	231,880,000
Холбоотой талтай хийсэн борлуулалт	88,682	178,110
Холбоотой талаас авсан худалдан авалт	483,131	1,373,919
Хүүгийн орлого	-	195,185
Хүүгийн зардал	2,471,831	4,480,753
Түрээсийн орлого	182,860	192,032
Түрээсийн зардал	1,016,289	1,030,538


Жич: Холбоотой талууд гэдэгт Таван Богд Группийн охин компаниуд орсон болно. Эдгээр холбоотой талуудтай компанийн өдөр тутмын үйл ажиллагаанд зайлшгүй шаардлагатай бараа үйлчилгээг зах зээлийн үнэ, нөхцөлөөр худалдан авах болон худалдах зөвшөөрлийг ТУЗ-ийн 2023.02.03-ны №03 тоот тогтоолоор олгосон болно.

5. Үнэт цаас гаргагч нь төсөл хэрэгжүүлэх зорилгоор олон нийтэд санал болгон хувьцаа гаргасан бол төсөл хэрэгжиж эхэлснээс хойших төслийн хэрэгжилтийн явц, татан төвлөрүүлсэн хөрөнгийн зарцуулалтын тайлан, мэдээлэл

Олон нийтэд санал болгон хувьцаа гаргаагүй.

6. Компанийн засаглалтай холбоотой мэдээлэл

ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧИД



НИЙТ ХУВЬЦААНЫ ТОО

780,112,500

НИЙТ ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧИДИЙН ТОО

23,762

/2023.09.15-ны байдлаар/

Нөлөө бүхий хувьцаа эзэмшигчид

Хувьцаа эзэмшигчийн нэр	Хувьцааны тоо (ширхэг)	Эзэмшлийн хувь
Таван Богд Трейд ХХК	400,140,072	51.29%
Хиде Интер ХХК	265,238,300	34.00%

2023.09.15-ны байдлаар нийт 23,762 хувьцаа эзэмшигчидтэй байна. Компанийн нөлөө бүхий хувьцаа эзэмшигчид нь Таван Богд Трейд ХХК болон Хиде Интер ХХК бөгөөд тайлант хугацаанд нөлөө бүхий хувьцаа эзэмшигчдийн бүрэлдэхүүнд өөрчлөлт ороогүй.

Хувьцаа эзэмшигч ажилтан

Говь ХК нь 2021 оны 6-р сард “Ажилтанд хувьцаа эзэмшүүлэх хөтөлбөр”-ийг албан ёсоор эхлүүлсэн. Энэхүү хөтөлбөр нь ажилтнуудын хувьд өөрийн гараар бүтээсэн баялгаасаа хувь хүртэж, сэтгэл хангалуун бөгөөд тогтвор суурьшилтай ажиллах хөшүүрэг болохоос гадна ажилтан бүрийн оролцоог нэмэгдүүлэх зорилготой юм.

2023.09.30-ны байдлаар компанийн 992 ажилтан 540,000 ширхэг буюу 0.07% хувьцааг эзэмшиж байна.

Цаашид ТУЗ болон компанийн удирдлагуудын зүгээс энэхүү хөтөлбөрөө үргэлжлүүлэн тогтмол хэрэгжүүлэхээр төлөвлөгөө боловсруулан ажиллаж байна.

ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРАЛ

Говь ХК-ийн хувьцаа эзэмшигчдийн эрхээ хэрэгжүүлэх гол хэлбэр нь Хувьцаа эзэмшигчдийн хурал бөгөөд Хувьцаа эзэмшигчдийн хурал нь компанийн эрх барих дээд байгууллага юм. Компани Хувьцаа эзэмшигчдийн хурлаараа Компанийн тухай хуулийн 62.1-г заасан Хувьцаа эзэмшигчдийн хурлын бүрэн эрхэд хамаарах болон ТУЗ-өөс эсвэл компанийн дүрмээр хувьцаа эзэмшигчдийн хурлаар хэлэлцүүлж шийдвэрлэхээр тогтоосон компанийн удирдлага зохион байгуулалт, үйл ажиллагааны гол асуудлуудыг хэлэлцүүлэн шийдвэрлүүлдэг.

2023 оны ээлжит хурал

Говь ХК-ийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал 2023 оны 4-р сарын 20-ны өдрийн 10:00 цагт компанийн МҮХАҮТ-ын Их Танхимд амжилттай зохион байгуулагдав.

Хурлын ирц

Хуралд урьдчилан санал өгөх арга хэлбэрээр нийт 284,381,205 (36.45%) саналын эрхтэй 829 хувьцаа эзэмшигч, хурлын өдөр биечлэн оролцох арга хэлбэрээр 406,030,659 (52.05%) саналын эрхтэй 68 хувьцаа эзэмшигч буюу нийт 690,411,864 саналын эрхтэй 897 хувьцаа эзэмшигч оролцсоноор хурлын ирц 88.50% болж бүрдэн хурал хүчин төгөлдөр явагдав.

Хурлаар танилцуулсан асуудал

1. Говь ХК-ийн 2022 оны үйл ажиллагаа болон санхүү үр дүнгийн тайлан
2. 2022 оны санхүүгийн үр дүнгээс ногдол ашиг тараахгүй тухай ТУЗ-ийн тогтоол
3. ТУЗ-өөс компанийн 2022 оны үйл ажиллагаа болон санхүүгийн тайлангийн талаар гаргасан дүгнэлт
4. ТУЗ-ийн 2022 оны ажлын тайлан
5. ТУЗ-ийн гишүүдийн цалингийн хэмжээг шинэчлэх төсөл
6. ТУЗ-ийн 2023 оны цалингийн төсөв
7. ТУЗ-ийн гишүүнд нэр дэвшигчдийн танилцуулга

Хурлаас гарсан шийдвэр

Хувьцаа эзэмшигчид дээрх асуудлуудтай холбогдох тайлан илтгэлүүдийг сонсож, асуулт хариулт болон санал шүүмжлэлээ хэлэлцсэний эцэст саналын хуудсаар саналаа өгсөн бөгөөд Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаас дараах шийдвэрийг гаргав.

1. ТУЗ-өөс “Говь ХК-ийн гүйцэтгэх удирдлагын баг 2022 онд төлөвлөгдсөн зорилгоо биелүүлэхийн тулд өөрсдийн нөөц бололцоогоо бүрэн дүүрэн ашиглан ажилласан” гэсэн дүгнэлт өгснийг 99.99%-ийн саналаар батлав.
2. ТУЗ-ийн гишүүдийн цалингийн хэмжээг шинэчлэн тогтоох саналыг 99.99%-ийн саналаар батлав.
3. ТУЗ-ийн 2023 оны цалингийн төсвийг 99.99%-ийн саналаар батлав.
4. ТУЗ-ийн гишүүдийг 4 хараат бус гишүүн, 5 ердийн гишүүн буюу нийт 9 гишүүний бүрэлдэхүүнтэйгээр 3 жилийн хугацаатай томилов.

Хурлын дараах тайлан

Хурлын үеэр хувьцаа эзэмшигчдээс асуулт болон санал зөвлөмжийг хүлээн авч хурлын дараа эргэн холбогдож хариу өгч ажилласан.

2023.04.25-ны өдөр ХЭХ-ын материал (131 хуудас хэвлэмэл материал, 1 ном, 2 цахим хэлбэрийн материал)-ыг СЗХ, МХБ-д тус тус хүргүүлэн, хуулийн хугацаанд тайлагнан ажилласан.



ТУЗ-ИЙН БҮРЭЛДЭХҮҮН

ТУЗ-ийн хараат бус гишүүд



Дамбын ГЭРЭЛМАА

ТУЗ-ийн дарга, Нэр дэвшүүлэх хорооны гишүүн, Цалин урамшууллын хорооны гишүүн

СЭЗИС, Бизнес удирдлагын тэнхимийн профессор



Дамбийжавын ХҮРЭЛБААТАР

Нэр дэвшүүлэх хорооны дарга, Цалин урамшууллын хорооны дарга



Алтангэрэлийн ЖАРГАЛМАА

Эрсдэл, аудитын хорооны дарга

GAPE, ACCA ахлах баги, хөтөлбөрийн удирдагч



Такэши КАМБЭ

Цалин урамшууллын хорооны гишүүн


Япон улсын Asahi Life Insurance компанийн менежер

ТУЗ-ийн ердийн гишүүд



Цагаачийн БААТАРСАЙХАН

Таван Богд Группийн Ерөнхийлөгч, Говь ХК-ийн Гүйцэтгэх захирал



Дашдаваагийн ХУЛАН

Эрсдэл, аудитын хорооны гишүүн

Таван Богд Группийн Тэргүүн дэд ерөнхийлөгч



Хидэо САВАДА


Япон улсын H.I.S компанийн Ерөнхийлөгч



Баатарсайханы АМАРСАЙХАН

Цалин урамшууллын хорооны гишүүн

Говь ХК-ийн Стратеги, өсөлт хөгжил хариуцсан захирал



Цогтгэрэлийн ОРГИЛБОЛД

Нэр дэвшүүлэх хорооны гишүүн

Говь ХК-ийн Тэргүүн дэд захирал /Дизайн, үйлдвэрлэл, дэмжих/

7. Үнэт цаас гаргагчийн засаглалтай холбоотой тайлан, мэдээлэл

ТУЗ-ИЙН ХУРЛЫН МЭДЭЭЛЭЛ

Хурал	Ээлжит хурал	Ээлжит бус хурал	Хэлэлцсэн асуудал	Шийдвэр	Санал зөвлөмж	Үүрэг даалгавар	Баталсан тогтоол
ТУЗ-ийн хурал	4	9	46	40	12	16	33
Эрсдэл, аудитын хорооны хурал	3	2	17	13	9	3	4
Нэр дэвшүүлэх хорооны хурал	2	2	18	14	7	6	3
Цалин урамшууллын хорооны хурал	2	-	13	8	4	1	-
Нийт	11	13	94	75	32	26	40

- ТУЗ-ийн ээлжит хурлыг 2023.02.03, 2023.04.17, 2023.05.18, 2023.08.16-ны өдөр, ээлжит бус хурлыг 2023.03.06, 2023.03.10, 2023.03.20, 2023.05.26, 2023.05.31, 2023.06.26, 2023.07.06, 2023.08.01, 2023.09.22-ны өдрүүдэд;
- Нэр дэвшүүлэх хорооны ээлжит хурлыг 2023.01.16, 2023.08.07-ны өдөр, ээлжит бус хурлыг 2023.02.27, 2023.09.11-ний өдрүүдэд;
- Цалин урамшууллын хорооны ээлжит хурлыг 2023.01.16, 2023.08.07-ны өдрүүдэд;
- Эрсдэл, аудитын хорооны ээлжит хурлыг 2023.03.30, 2023.06.27, 2023.09.26-ны өдөр, ээлжит бус хурлыг 2023.04.17, 2023.07.19-ний өдрүүдэд тус тус зохион байгуулсан.

ТУЗ-ИЙН ТОГТООЛ, ШИЙДВЭР

Тайлант хугацаанд ТУЗ болон ТУЗ-ийн дэргэдэх хороод нийт 94 асуудлыг хэлэлцэн, 75 шийдвэр гаргаж, 40 тогтоолыг баталсан. Үүнд:

- ТУЗ-өөс 33 тогтоол (дотоод үйл ажиллагаатай холбоотой 22 тогтоол, санхүүжилттэй холбоотой 8 тогтоол, үйл ажиллагаа өргөжүүлэх, хөрөнгө оруулалттай холбоотой 2 тогтоол, хүний нөөцтэй холбоотой 1 тогтоол)
- Нэр дэвшүүлэх хорооноос 3 тогтоол,
- Эрсдэл, аудитын хорооноос 4 тогтоол.

Мөн чиг үүргийнхээ хүрээнд удирдлагуудад 32 санал зөвлөмж, 26 үүрэг даалгавруудыг өгч, хэрэгжилтэд нь хяналт тавин ажиллаж байна.

НОГДОЛ АШИГ

Говь ХК-ийн ТУЗ-ийн 2023 оны 2-р сарын 3-ны өдрийн №2 тоот тогтоолын дагуу компанийн 2022 оны санхүүгийн үр дүн нь компанийн ногдол ашгийн бодлогын 2.3-т заасан ногдол ашиг олгох нөхцөлийг хангаагүй буюу санхүүгийн зохистой харьцааг хангахгүй байгаа тул ногдол ашиг хуваарилахгүй байхаар шийдвэрлэсэн.

МЭДЭЭЛЛИЙН ИЛ ТОД БАЙДАЛ, ТАЙЛАГНАЛ

3-р улирлын байдлаар дараах тайлан мэдээллийг хуулийн хугацаанд СЗХ болон МХБ рүү илгээн, олон нийтэд тайлагнан ажилласан.

- 2022 оны Жилийн үйл ажиллагааны тайлан (монгол, англи хэл дээр);
- 2022 оны Аудитлагдсан санхүүгийн тайлан, аудитын дүгнэлт (монгол, англи хэл дээр);
- 2022 оны Байгаль орчин, нийгэм, засаглалын үйл ажиллагааны тайлан;
- 2022 оны Тогтвортой хөгжлийн тайлан;
- 2023 оны Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал зохион байгуулсан тайлан материал;
- 2023 оны 1-р улирал болон хагас жилийн санхүү, үйл ажиллагааны тайлан;
- Компанийн засаглалын кодексийн хэрэгжилтийн тайлан (2022.12.31, 2023.04.30, 2023.06.30-ны байдлаар);

Манай компани мэдээллийн ил тод байдлын хэрэгжилтийг ханган, цахим хуудсаараа дамжуулан хувьцаа эзэмшигчдийгээ тогтмол мэдээллээр ханган ажилладаг. 2023 онд info.gobi.mn компанийн веб хуудсын агуулга, дизайныг шинэчлэн хөрөнгө оруулагч, хувьцаа эзэмшигч нарт зориулсан цэсийг сайжруулж, [хувьцаа эзэмшигч эсэхээ шалгах](#), [ногдол ашиг авах хүсэлт илгээх](#) зэрэг цэсийг шинээр нэмсэн бөгөөд гадаад хувьцаа эзэмшигч нартаа зориулан цахим хуудсаа давхар англи хэл дээр ажиллуулан эхлээд байна.

Мөн бид хувьцаа эзэмшигчдийнхээ [асуулт, санал хүсэлт](#)-ийг цахим хуудсаараа дамжуулан хүлээн авахаас гадна дуудлага, и-мэйлд дор бүр нь хариу өгч, шийдвэрлэн ажиллаж байна. 2023 оны 3-р улиралд “Хөрөнгө оруулагчидтай харилцах хөтөлбөр”-ийнхөө хүрээнд хувьцаа эзэмшигч нартаа зориулан [гарын авлага](#)-ыг боловсруулсан. Энэхүү гарын авлаганаас хувьцаа эзэмшигч нар Говь ХК-ийн компанийн засаглал, ТУЗ-ийн үйл ажиллагаа, хувьцаа эзэмшигчдийн эрх үүрэг, ногдол ашиг болон бусад мэдээллийг авах боломжтой.

ШИНЭЭР БАТЛАГДСАН БОДЛОГЫН БАРИМТ БИЧГҮҮД

Говь ХК нь “[Компанийн засаглалын кодексийн хэрэгжүүлэх хөтөлбөр](#)”-ийг 2022 оны 11-р сард баталсан бөгөөд тус хөтөлбөрийн хэрэгжилтийг хангах зорилгоор 2023 онд ТУЗ-өөс дараах бодлого, журмыг баталсан. Үүнд:

- Компанийн хэмжээнд 2020 оноос хойш бодлогын чанартай баримт бичгүүд олноор шинэчлэн батлагдсан учир эдгээр бодлогуудтай уялдуулж “[Эрсдэлийн удирдлагын бодлого](#)”-ыг шинэчлэх төслийг Эрсдэл аудитын хорооны хурлаар хэлэлцэн, 2-р сарын 3-ны ТУЗ-ийн хурлаар шинэчлэн баталсан.
- “[Эрх бүхий албан тушаалтнуудын залгамж халааны бодлого](#)”, “[ТУЗ-ийн гишүүнийг сонгон шалгаруулах, нэр дэвшүүлэх журам](#)”-ыг шинээр боловсруулан, Нэр дэвшүүлэх хорооны хурлаар хэлэлцэн, 2-р сарын 3-ны ТУЗ-ийн хурлаар баталсан.
- ТУЗ-ийн гишүүдтэй байгуулах санамж бичиг болон Нууц хадгалах гэрээний загварыг 1-р сарын 16-ны Нэр дэвшүүлэх хорооны хурлаар баталсан.
- Хөрөнгө оруулагч, хувьцаа эзэмшигч нарынхаа оролцоог хангах, эрх ашгийн тэнцвэртэй байдал болон мэдээллийн ил тод байдлын хэрэгжилтийг хангах зорилгоор “[Хөрөнгө оруулагчидтай харилцах хөтөлбөр](#)”-ийг боловсруулан, 4-р сарын 17-ны ТУЗ-ийн хурлаар баталсан.
- Гүйцэтгэх захиралтай байгуулах гэрээний загварыг 8-р сарын 7-ны Нэр дэвшүүлэх хорооны хурлаар хэлэлцэн боловсруулж, 8-р сарын 16-ны хурлаар батлан, Гүйцэтгэх захиралтай Менежментийн гэрээгээ шинэчлэн байгуулсан.
- Компанийн засаглалын кодексийн хүрээнд ТУЗ-ийн дэргэдэх [Эрсдэл, аудитын хороо](#), [Нэр дэвшүүлэх хороо](#), [Цалин урамшууллын хороо](#)-ны үйл ажиллагааны журмыг шинэчлэн боловсруулж, 8-р сарын 16-ны ТУЗ-ийн хурлаар баталсан.
- Компанийн хэмжээнд 2022 оны 11-р сараас хэрэгжүүлж эхэлсэн шүтэл үлээх системийн үйл ажиллагаатай уялдуулан “[Шүтэл үлээх тогтолцооны үйл ажиллагааны журам](#)”-ыг шинэчлэн боловсруулж, 8-р сарын 16-ны ТУЗ-ийн хурлаар баталсан.

ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ҮЙЛДВЭРТЭЙ ТАНИЛЦАХ АЯЛАЛ

Хөрөнгө оруулагчидтай харилцах хөтөлбөрийн хүрээнд хэрэгжүүлэх нэг онцлох ажил болох “Хувьцаа эзэмшигч нарын үйлдвэртэй танилцах аялал”-ыг 2023 оны 4-р сарын 7 болон 9-р сарын 29-ний өдрүүдэд амжилттай зохион байгуулсан.



КОМПАНИЙН ЗАСАГЛАЛЫН КОДЕКСИЙН ХЭРЭГЖИЛТИЙН ҮНЭЛГЭЭ

Говь ХК-ийн зүгээс “Компанийн засаглалын кодекс”-ийн хэрэгжилтийн үнэлгээг 2023 оны эхний хагас жилийн байдлаар хийсэн бөгөөд СЗХ-ноос хараат бусаар давхар үнэлэн үр дүнг хянан баталгаажуулсан.

№	Гарчиг	Авбал зохих оноо	2022.12.31-ний байдлаар		2023.06.30-ны байдлаар			Өсөлт хувь
			Үнэлсэн оноо	Үнэлгээний хувь	Үнэлсэн оноо	СЗХ-ны хяналтын оноо	Үнэлгээний хувь	
1	ТУЗ-ийн бүтэц, зохион байгуулалт	12	10	83.3%	11	11	91.7%	8.4%
2	ТУЗ-ийн дэргэдэх хороод, тэдгээрийн чиг үүрэг	10	9	90.0%	10	10	100.0%	10.0%
3	Тайлагнал, мэдээллийн ил тод, байдал	6	6	100.0%	6	6	100.0%	-
4	Аудит, хяналтын тогтолцоо	6	6	100.0%	6	6	100.0%	-
5	Эрсдэлийн удирдлага	8	8	100.0%	8	8	100.0%	-
6	Эрх бүхий албан тушаалтны цалин урамшуулал	6	4	66.7%	6	6	100.0%	33.3%
7	Оролцогч талуудын эрх ашиг	8	6	75.0%	8	8	100.0%	25.0%
8	Компанийн соёл	6	6	100.0%	6	6	100.0%	-
9	Хувьцаа эзэмшигчдийн эрх	10	9	90.0%	10	10	100.0%	10.0%
	Нэгдсэн дүн	72	64	88.9%	71	71	98.6%	9.7%

Нэгдсэн дүнгээс харахад Говь ХК-ийн “Компанийн засаглалын кодекс”-ийн хэрэгжилтийн үнэлгээ нь 2022 оны эцсээр 88.9% буюу дунд засаглалтай байсан бол 2023 оны эхний хагас жилийн байдлаар 98.6% болж 9.7% өссөн бөгөөд **засаглал хэвийн, эрсдэлгүй** гэж үнэлэгдсэн. ТУЗ-ийн зүгээс 2022 оны үнэлгээний үр дүнд үндэслэн 2023 оны эхэнд цаашид сайжруулах шаардлагатай ажлуудаа тодорхойлон анхаарч ажиллаж байна. Улмаар 2022 оны үйл ажиллагааны тайланд оруулах мэдээллийн агуулгаа сайжруулснаас гадна 2023 онд бодлогын баримт бичгүүдийг шат дараатай шинээр боловсруулан баталсан нь ийнхүү үнэлгээний үр дүн өсөхөд нөлөөлсөн гэж дүгнэж байна.

Бид цаашид өдөр тутмын үйл ажиллагаандаа батлагдсан дүрэм журмуудынхаа хэрэгжилтийг ханган ажиллаж, хувьцаа эзэмшигчдийнхээ эрх ашгийн тэнцвэртэй байдлыг хангах, мэдээллийн ил тод байдлыг хангахад анхаарч ажиллах болно.

Засаглалын үнэлгээний дэлгэрэнгүй тайлантай [энд дарж](#) танилцах боломжтой.

ХУВЬЦААНЫ ХАНШ


Говь ХК-ийн зах зээлийн үнэлгээ 2023.09.30-ны байдлаар 231.6 тэрбум төгрөг буюу 2022 оны эцсээс 19.5% өссөн үзүүлэлттэй байна.

Үзүүлэлт	2022.12.31	2023.09.30	Өсөлт, бууралт энгийн хувьцаа
ГАРГАСАН ХУВЬЦААНЫ ТОО /шир/	780,112,500	780,112,500	
ХУВЬЦААНЫ ҮНЭ /төг/			
Хаалтын үнэ	248.32	296.86	19.5%
Хамгийн их үнэ	311.50	350.00	12.4%
Хамгийн бага үнэ	242.73	240.69	-0.8%
Дундаж үнэ	272.19	265.16	-2.6%
АРИЛЖААЛАГДСАН ТОО /шир/			
Хамгийн их /өдөрт/	1,234,986	7,500,000	507.3%
Хамгийн бага /өдөрт/	392	179	-54.3%
Дундаж /өдөрт/	30,702	69,896	127.7%
Нийт	7,552,604	12,930,678	71.2%
АРИЛЖААНЫ ҮНИЙН ДҮН /төг/			
Хамгийн их /өдөрт/	336,411,123	2,625,000,000	680.3%
Хамгийн бага /өдөрт/	107,018	52,805	-50.7%
Дундаж /өдөрт/	8,519,435	21,892,571	157.0%
Нийт	2,095,780,903	4,050,125,723	93.3%
ЗАХ ЗЭЭЛИЙН ҮНЭЛГЭЭ /төг/	193,717,536,000	231,584,196,750	19.5%




8. *Үйл ажиллагаатай холбоотой бусад нэмэлт мэдээлэл*

БОРЛУУЛАЛТ, ЦЭВЭР АШИГ



БОРЛУУЛАЛТЫН ОРЛОГО, СЕГМЕНТЭЭР (тэрбум төгрөг, %)



САНХҮҮГИЙН ҮР ДҮН

ҮЗҮҮЛЭЛТ	Хэмжих нэгж	Гүйцэтгэл	Гүйцэтгэл	Өмнөх оноос өсөлт	
		2022.09.30	2023.09.30	тоо	хувь
БОРЛУУЛАЛТЫН ОРЛОГО	<i>сая.төг</i>	104,800	166,376	61,576	59%
Үүнээс: Дотоод борлуулалт	<i>сая.төг</i>	54,997	103,615	48,618	88%
Экспортын борлуулалт	<i>сая.төг</i>	31,115	39,860	8,745	28%
Гадаад борлуулалт	<i>сая.төг</i>	18,688	22,901	4,213	23%
Борлуулсан бүтээгдэхүүний тоо ширхэг	<i>мян.шир</i>	551	739	188	34%
БОРЛУУЛСАН БҮТЭЭГДЭХҮҮНИЙ ӨРТӨГ	<i>сая.төг</i>	55,826	86,584	30,758	55%
НИЙТ АШИГ	<i>сая.төг</i>	48,974	79,792	30,818	63%
Бохир ашгийн хувь	<i>хувь</i>	47%	48%		1%
Үйл ажиллагааны зардал	<i>сая.төг</i>	57,613	81,031	23,419	41%
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ АШИГ	<i>сая.төг</i>	(8,639)	(1,239)	7,400	86%
Үйл ажиллагааны ашгийн хувь	<i>хувь</i>	-8%	-1%		7%
Үйл ажиллагааны бус зардал	<i>сая.төг</i>	5,164	1,641	(3,522)	-68%
Татварын өмнөх ашиг	<i>сая.төг</i>	(13,802)	(2,881)	10,922	79%
ЦЭВЭР АШИГ/АЛДАГДАЛ	<i>сая.төг</i>	(13,488)	(3,883)	9,605	71%
Цэвэр ашгийн хувь	<i>хувь</i>	-13%	-2%		11%
Нийт үйл ажиллагааны зардал	<i>сая.төг</i>	113,439	167,615	54,176	48%
ҮЙЛДВЭРЛЭЛ	<i>мян.шир</i>	586	757	172	29%
Сүлжмэл бүтээгдэхүүн	<i>мян.шир</i>	471	545	74	16%
Нэхмэл бүтээгдэхүүн	<i>мян.шир</i>	86	186	101	117%
Оёмол бүтээгдэхүүн	<i>мян.шир</i>	29	26	-3	-9%
Пальто	<i>мян.шир</i>	11	13	1	11%
Пиджак	<i>мян.шир</i>	5	4	-1	-15%
Ээрмэл утас	<i>тонн</i>	113	204	91	81%
АЖИЛТНУУДЫН ТОО	<i>хүн</i>	1,533	1,667	134	9%
Нэг ажилтанд ногдох орлого	<i>мян.төг</i>	68,363	99,746	31,383	46%
ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ	<i>сая.төг</i>	2,316	3,162	847	37%
НИЙТ ӨР ТӨЛБӨР	<i>сая.төг</i>	306,976	349,817	42,842	14%
Үүнээс: Банкны зээл	<i>сая.төг</i>	264,236	258,908	(5,328)	-2%
НИЙТ ХӨРӨНГӨ	<i>сая.төг</i>	320,485	354,981	34,496	11%
Үүнээс: Бараа материал	<i>сая.төг</i>	143,491	163,243	19,752	14%
МАРКЕТИНГИЙН ЗАРДАЛ	<i>сая.төг</i>	11,483	13,560	2,077	18%
Үүнээс: Гадаад маркетинг	<i>сая.төг</i>	10,754	12,051	1,297	12%

САНХҮҮЖИЛТИЙН МЭДЭЭЛЭЛ

(мян. төг)

№	Санхүүжүүлэгчийн нэр	Санхүүжилтийн хэлбэр	Валют	Жилийн хүүгийн хувь	Дуусах хугацаа	Зээлийн үлдэгдэл 2022.12.31	Зээлийн үлдэгдэл 2023.09.30
1	Голомт банк	Зээлийн шугам	Төгрөг	15.65%	2024	-	48,205,000
2	Хаан банк	Зээлийн шугам	Төгрөг	12.60%	2025	-	11,000,000
3	Хас банк	Зээлийн шугам	Төгрөг	15.60%	2023	9,566,000	-
4	Голомт банк	Урт хугацаат зээл	Төгрөг	11.00%	2025	20,000,000	15,833,333
5	Хаан банк	Богино хугацаат зээл	Төгрөг	5.00%	2024	10,000,000	10,000,000
6	Хас банк	Богино хугацаат зээл	Төгрөг	5.00%	2024	-	25,000,000
7	Ариг банк	Богино хугацаат зээл	Төгрөг	5.00%	2024	-	14,500,000
8	Хаан банк	Урт хугацаат зээл	Төгрөг	3.00%	2024	-	6,700,178
9	Монгол Улсын Хөгжлийн Банк	Богино хугацаат зээл	Төгрөг	11.50%	2022	33,333,333	15,000,000
10	Монгол Улсын Хөгжлийн Банк	Богино хугацаат зээл	Төгрөг	12.00%	2023	42,900,000	15,000,000
11	Европын Сэргээн Босголт Хөгжлийн Банк (Транч 1А)	Богино хугацаат зээл	Доллар	6.79%	2024	6,262,909	3,774,000
12	Европын Сэргээн Босголт Хөгжлийн Банк (Транч 1Б)	Богино хугацаат зээл	Доллар	7.49%	2024	9,394,364	5,661,000
13	Европын Сэргээн Босголт Хөгжлийн Банк (Транч 2)	Богино хугацаат зээл	Доллар	6.93%	2024	11,273,237	7,548,000
14	Олон Улсын Хөрөнгө Оруулалтын банк	Урт хугацаат зээл	Евро	5.25%	2027	51,366,280	51,346,260
15	Олон Улсын Хөрөнгө Оруулалтын банк	Урт хугацаат зээл	Евро	4.25%	2027	29,352,160	29,340,720
Нийт зээлийн дүн						223,448,283	258,908,491

Монгол банкны хани /төг/:

	2022-12-31	2023-09-30
USD	3,444.60	3,459.50
EUR	3,669.02	3,667.59

КОМПАНИЙН УДИРДЛАГЫН ЗАРДАЛ

(мян. төг)

ЗАРДЛЫН ТӨРӨЛ	2022.09.30	2023.09.30
ТУЗ-ийн гишүүдийн цалин урамшуулал	111,300	113,700
Менежмент багийн удирдлагын цалин урамшуулал	978,100	1,308,987
Хувьцаа эзэмшигчдийн хурлын зардал	22,218	21,331

ДОТООДЫН ЗАХ ЗЭЭЛ



Мэргэжлийн стилистийн зөвлөх үйлчилгээ

Галлериа салбар болон Төв дэлгүүр дээр мэргэжлийн стилистийн зөвлөх үйлчилгээг шинээр нэвтрүүлэн хэрэглэгчдэд стилистийн үйлчилгээг үзүүлж байна.



SARANTSATSRALT
SER-OD

X
GOBI
MONGOLIAN CASHMERE

“Тэргүүлэгч цэцэг яргуй” коллекц

Төрийн соёрхолт С.Саранцацралт зураачтай хамтран “Тэргүүлэгч цэцэг яргуй” цагаан сарын коллекцийг амжилттай гаргасан нь хэрэглэгчдээс сэтгэл ханамжийн өндөр үнэлгээг авсан.



Аялал жуулчлалын улирлын нээлт

Аялал жуулчлалын улирлыг угтан 2023.04.19-ний өдөр 200 гаруй хөтөч, жолооч, аяллын компаниудыг хүлээн авч "Аялал жуулчлалын улирлын нээлт"-ийн арга хэмжээг амжилттай зохион байгуулсан бөгөөд 30 гаруй компани, 80 гаруй хөтөч нартай хамтран ажиллаж байна.



Төв дэлгүүрийн шинэчлэлт

Үйлдвэрийн дэргэдэх Төв дэлгүүрийн өргөтгөл “Мираж” рестораны 679 м2 талбайг шинэчлэн засвар хийж дэлгүүрийн талбайгаа өргөтгөн, орчин үеийн интерьер дизайнтайгаар 2023.05.25-ны өдөр бүрэн ашиглалтад оруулсан. Шинэчлэн засварласан хэсэгт эрэгтэй тасаг байрлаж байгаа бөгөөд хэрэглэгчдэд илүү тав тухтай орчныг бүрдүүлэх зорилгоор Coffee shop нээн ажиллуулж байна.



Giorgio Spina загварын шоу

Ерөнхий дизайнер Giorgio Spina-гийн анхны коллекц болох THE FACE Pre-Fall 23 болон MATERIA Organic Pre-Fall 23 коллекцийн загварын шоу дэлхийн хэмжээний өндөр зохион байгуулалттайгаар 2023.06.08-ны өдөр амжилттай зохион байгуулсан.



Монголын Эдийн Засгийн Форум 2023

Говь ХК нь Монголын Эдийн Засгийн Форум 2023-д оролцон нийт гаднын 1,500 гаруй хөрөнгө оруулагч, зочид төлөөлөгчдөд Говь ХК-ийн тухай танилцуулга, мэдээлэл хүргэн ажилласан.


Жуулчдын улиралд зориулсан нэмэлт үйлчилгээ



2023 оны 6-р сараас эхлэн Жуулчдын улиралд зориулан борлуулалтыг дэмжих, хэрэглэгчдийн сэтгэл ханамжийг нэмэгдүүлэх зорилгоор дараах нэмэлт үйлчилгээг санал болгож хэрэгжүүлсэн.

1. Жуулчны улирал болох 6-9-р сарын хооронд 2 дэлгүүрт өдөрт 3 удаа загварын шоу үзүүлбэрийг зохион байгуулсан.
2. Жуулчдад зориулсан Үйлдвэртэй танилцах аяллын 25 минутын богино хөтөлбөр гарган Англи, Хятад, Солонгос хэл дээр тогтмол танилцуулсан.

Жуулчдын борлуулалт



2023 оны 3-р улирлын байдлаар дотоодын зах зээлийн нийт борлуулалт 103.6 тэрбум төгрөг буюу 88%-р өссөн бөгөөд үүний 44%-ийг жуулчдын борлуулалт эзэлж байна. Өмнөх оны мөн үетэй харьцуулахад жуулчдын борлуулалт 3.4 дахин өссөн үзүүлэлттэй байна.

ЭКСПОРТЫН ЗАХ ЗЭЭЛ

Экспортын зах зээлийн хувьд манай компани цөөн, чанартай стратегийн харилцагчидтай хамтран ажиллах бодлогыг баримталж байгаа бөгөөд 2023 оны 3-р улирлын байдлаар 44 харилцагчид бүтээгдэхүүнээ нийлүүлж, нийт борлуулалт 39.9 тэрбум төгрөг буюу өмнөх оны мөн үеэс 28% өссөн үзүүлэлттэй байна. (7 улсын 19 хотод 20 франчайз дэлгүүртэй)



Парис хотод харилцагч нартай хийсэн бизнес уулзалт

2023 оны 1-р сард Франц улсын Парис хотод харилцагч нартай бизнес уулзалтууд хийж, шинэ коллекцийн танилцуулгаа хийсэн. Ийнхүү харилцагчидтай биечлэн уулзаж харилцагчийн үйл ажиллагаатай нь дэлгэрэнгүй танилцсанаар итгэлцэл, хамтын ажиллагаа сайжирч борлуулалтын өсөлтөд эергээр нөлөөлсөн.



Солонгос улсын харилцагчаар дамжуулан 2023 оноос эхлэн Lotte Home Shopping сувгаар Goyo брэндээр борлуулалт хийж эхэлсэн.

ГАДААД ЗАХ ЗЭЭЛ

2023 оны 3-р улирлын байдлаар гадаад зах зээлийн нийт борлуулалт 22.9 тэрбум төгрөг буюу өмнөх оны мөн үеэс 23%-р өссөн.



INSTAGRAM VERIFIED BADGE




Говь брэндийн органик хайлт

SEO буюу Search Engine Optimization компаниудтай хамтран ажиллаж брэндийн органик хайлтыг сайжруулах ажлуудыг хийж байна. Үр дүнд нь өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад Говь брэндийн органик түлхүүр үгсийн зэрэглэл 3.1 дахин сайжирсан үр дүнтэй байна.

Instagram-ийн албан ёсны таних тэмдэг

Gobi Cashmere-ийн бүх зах зээлийн 11 Instagram хаягнууд албан ёсны таних тэмдгийн баталгаажуулалтаа авсан. Энэхүү албан ёсны таних тэмдгийг олон төрлийн шалгууруудыг давсан, олонд танигдсан брэндүүдэд олгодог бөгөөд Говь брэндийг илүү итгэл даахуйц, албан ёсны гэдгийг олон улсын хэрэглэгчдэд баталгаажуулах нэг алхам болох юм.



Data Science

Гадаад борлуулалтын газар нь хэрэглэгчдийн нэгдсэн датаг бүрэн хэмжээнд боловсруулан ашиглахын тулд 2023 оноос эхлэн Data Science ашиглаж эхэлсэн. Ингэснээр худалдан авалтын замналыг тодорхойлон мэдээллийн нэгдсэн дата платформтой болж, дата боловсруулалтыг хийн, борлуулалтын таамаглалыг илүү бодитой гаргадаг болох ажлуудыг амжилттай хийж байна.



CNN TV-ийн нэвтрүүлэг

CNN TV-ийн зочид төлөөлөгчид Монгол улсад хүрэлцэн ирж бэлтгэсэн Made in нэвтрүүлэгтээ Говь ХК-ийн үйлдвэр, дэлгүүр болон компанийн үйл ажиллагааны талаар ярилцлага мэдээллийг бэлтгэн оруулсан нь 7-р сард цацагдаж эхэлсэн. Энэ нь дэлхий дахинд Говь брэндээ сурталчлах нэг алхам болсон.



PR агентлагуудтай хамтын ажиллагаа

Гадаад борлуулалтын маркетингийн хэлтэс нь зорилтот зах зээлд тохирсон PR агентлагуудтай хамтран ажилладаг ба 2023 оны 3-р улирлын байдлаар Америкийн зах зээлд L.E.R, Английн зах зээлд B.agency, Германы зах зээлд R+, Бельгийн зах зээлд Charaly PR гэсэн PR агентлагуудтай хамтран ажиллаж байна.

Ийнхүү хамтран ажилласны үр дүнд энэ онд Maya Musk, James Gunn, Kit Conner, Roman Pope Francis, Nas Daily гэх мэт 227 олны танил болон influencers, L'official, The magazine, GQ, Vogue, Elle, Cosmopolitan, The Guardian гэх мэт 120 сэтгүүл, редактортой хамтран ажиллаж, Showroom in New York, Berlin VIP fashion lounge, Berlin Beauty & Fashion Lounge гэх мэт 8 арга хэмжээнд оролцсон.

Зорилтот зах зээлийн PR агентлагуудтай хамтран ажилласнаар зах зээлийн танигдалт тасралтгүй нэмэгдэж цаг алдалгүй, өндөр чанарын ажилбар гүйцэтгэх боломжтой болдог.



GOBI
MONGOLIAN CASHMERE



Казахстан улс дахь охин компани

Гадаад борлуулалтын сувгаа нэмэгдүүлэх зорилгоор 9-р сард Бүгд Найрамдах Казахстан Улсад охин компаниа байгуулсан бөгөөд онлайн сувгийн борлуулалтын үйл ажиллагаагаа эхлүүлэх бэлтгэл ажлыг хангаад байна.

Харилцагчийн үзүүлэлт



2023 оны 2-р сард Salesforce болон Mirum компаниудтай хамтран харилцагчийн датанд аудит оруулсан. E-mail хаяггүй, давхардан бүртгүүлсэн хэрэглэгчдийн датаг цэгцэлж, идэвхгүй хэрэглэгчдийн мэдээллийг цэвэрлэснээр дата багтаамж суларч, чанартай, урт хугацааны харилцагч нар үлдсэн. Аудит орсны дараа 2023.09.30-ны байдлаар нийт 515,811 харилцагч бүртгэлтэй байгаа нь өмнөх оны мөн үеэс 3.1 дахин өсөлттэй байна.

Нэг харилцагчийг татах зардал 2022 оны 3-р улирлын байдлаар €44 байсан ба 2023 онд €10 болж 4.4 дахин буурсан үзүүлэлттэй байна.

МЭДЭЭЛЭЛ ТЕХНОЛОГИ



Microsoft

POWER PLATFORM



Centric PLM систем нэвтрүүлэлт

Олон улсын загварын салбарт PLM буюу Product Lifecycle Management системээр тэргүүлэгч Centric PLM системийг нэвтрүүлэх төслийг 2023 оны 1 сард эхлүүлсэн бөгөөд 7 сараас үйл ажиллагаандаа ашиглаж эхлэн тасралтгүй сайжруулалтуудыг хийж байна.

Энэхүү системийг үйл ажиллагаандаа нэвтрүүлснээр бүтээгдэхүүний санааг хөгжүүлэлтийн шатнаас бэлэн бүтээгдэхүүн болгон үйлдвэрлэх хүртэлх бүхий л процессыг үр бүтээмжтэй хийх, өртөг тооцооллыг бүрэн автоматжуулах, бараа материалын эргэцийн удирдлагыг сайжруулах зэрэг олон боломжийг бүрдүүлэх юм.

“SAP S/4 HANA” ERP төсөл

Компанийн хэмжээнд SAP ERP системийг нэвтрүүлэх төслийг 2023 оны 8 сард эхлүүлсэн бөгөөд 2024 оны 2-р улиралд үйл ажиллагаандаа бүрэн ашиглаж эхлэхээр төлөвлөж байна.

Тус системийг компанийн бүхий л үйл ажиллагааг хамарсан байдлаар буюу санхүү удирдлага, санхүү бүртгэл, материалын менежмент, үйлдвэр төлөвлөлт, үйлдвэр техник удирдлага, чанарын удирдлага, борлуулалт&дистрибьюшн гэсэн 7 модультайгаар нэвтрүүлэхээр төлөвлөж байна.

Ингэснээр бизнесийн процессыг сайжруулах, ажлын бүтээж нэмэгдүүлэх, шийдвэр гаргалтыг хурдан бөгөөд оновчтой болгох, хүний гар ажиллагааг багасгах зэрэг олон давуу талуудыг бүрдүүлэх юм.

Дотоод процесс автоматжуулалт


Үйл ажиллагааны процессыг богино хугацаанд хөгжүүлэлт хийх аргачлалыг ашиглан компанийн хэмжээнд ашиглагддаг 4 төрлийн цаасан хүсэлтийг цахим болгон хялбаршуулж ажлын бүтээмжийг нэмэгдүүлсэн. Мөн Эмнэлэг удирдлагын бүртгэлийн программ хангамжийг шинээр ашиглалтад оруулсан.

Мэдээллийн аюулгүй байдал

Нийт ажилтнууд руу чиглэсэн мэдээллийн аюулгүй байдлын зөвлөмжийг тогтмол хугацаанд хүргүүлэн фишинг симуляц хийх давтамжтай болохоор ажиллаж байна. Технологийн сайжруулалтын хүрээнд аюулгүй хандалтын протоколуудыг ашиглаж эхэлсэн.

Компанийн Мэдээллийн аюулгүй байдлын бодлогыг олон улсын ISO 27001-ийн дагуу боловсруулан, баталгаажуулсан.

ЗАГВАР, БҮТЭЭГДЭХҮҮН ХӨГЖҮҮЛЭЛТ



Ерөнхий дизайнер Giorgio Spina

Говь брэндийн ерөнхий дизайнераар дэлхийд танигдсан Италийн загвар зохион бүтээгч Giorgio Spina ажиллан анхны коллекц болох “Materia” Gobi Organic Pre-Fall 2023, “The Face” Gobi Pre-Fall 2023 хоёр коллекцоо танилцуулсан.

Энэхүү коллекцуудад нийт 135 загварын шинэчлэл хийж, олон төрлийн сүлжээс, нэхээсийг хослуулж, өнгө будгийн тоглолтыг нэг бүтээгдэхүүн дээр урласнаараа урьд өмнө байгаагүй шинэлэг шийдлийг бүтээж чадсан юм.

Мөн тэрээр 8-р сард Монголд дахин ирж Говь ХК дээр ажиллахдаа 2024 оны Хавар/Зуны коллекцийг дотоод болон гадаад борлуулалтын газруудад танилцуулахаас гадна дэлгүүрийн өнгө төрх, өрөлт хураалт зэрэг борлуулалтыг дэмжих нэгэн төрлийн арга болох Visual Merchandising дээр өөрийн үзэл бодол санал, чиглэлийг өгөн ажилласан. Энэ томилолтынхоо хугацаанд DeFacto болон Mongol HD - Terminal 1.0 нэвтрүүлгүүдэд уригдан нээлттэй ярилцлага өрнүүлсэн.

Ноолууран гутал

Тусгай аргаар боловсруулсан нягт өндөртэй шинэ төрлийн 100% ноолууран Felton материалыг гарган ноолууран бүтээгдэхүүн хөгжлийг нэг шатаар ахиулсан Монголдоо анхдагч ноолууран гутлыг Говь брэнд хөгжүүлэн дотоодын хэрэглэгчдэд хүргэсэн. Манай компанийн дизайн хөгжүүлэлтийн газар нь гутлын технологи дээр олон улсын томоохон брэндийн гутал хөгжүүлэлт дээр ажиллаж байсан туршлагатай мэргэжилтнээр удирдуулан гутлын хөгжүүлэлтээ хийж байна.

Материал хөгжүүлэлт

Хүний хэрэгцээ, бүтээгдэхүүний чанар, дэлхийн загварын чиг хандлагад тулгуурлан материал боловсруулалт дээрээ даавууны гадаргууг жигдлэх, хэлбэрээ хадгалах суналттай даавуу, үрчийлтгүй даавуу, угааж болдог даавуу гэх 4 төрлийн шинж чанартай нарийн даавуу хөгжүүлэн хэрэглээний шинж чанарын туршилт судалгааны ажил хийгдэж байна.



Даавууны гадаргууг жигдлэг болгох боловсруулалт 01

Боловсруулалтын аргаар хэлбэрээ хадгалах суналттай боловсруулалт 02

Үрчийлтгүй даавууны боловсруулалт 03

Угааж болдог боловсруулалт 04



Олон улсын үзэсгэлэн


Монголын ноос ноолуурын холбооноос хамтран 4 компани Францын Парис хотод зохион байгуулагдсан Premier Vision үзэсгэлэнд оролцож Монгол ноолуураа сурталчлан ажилласан. Мөнх Хөх-Хотод зохион байгуулагдсан Монгол Хятадын хамтын ажиллагааны 4 дэх удаагийн экспо үзэсгэлэнд баг бүрэлдэхүүн явж амжилттай оролцсон.

Хүндэтгэлийн бэлгүүд

Төрийн хүндэтгэлийн яам тамгын газрын захиалгаар төрийн өндөр айлчлал болон ирсэн зочид төлөөлөгчдөд зориулсан тусгай захиалгуудыг хийж гүйцэтгэсэн. Онцлон дурдвал, Ромын Пап Ламын айлчлал, Киргиз улсын ерөнхийлөгч, тэргүүн хатагтайн хамт.

КОЛЛЕКЦУУД

Манай компанийн Дизайн хөгжүүлэлтийн газрын мэргэшсэн чадварлаг хамт олон 2023 оны 3-р улирлын байдлаар үндсэн 6, нэмэлт 26 капсул буюу нийт 32 шинэ коллекц дотоод болон гадаадын борлуулалтын газруудад танилцуулснаас 3-р улирлын байдлаар 2022-2023 онд хийгдсэн цуглуулгуудаас 14 коллекц масс үйлдвэрлэл хийгдэн 2023 онд зураг авалтаараа дамжуулан хэрэглэгчдэд хүрч худалдаанд гарсан.



ТОГТВОРТОЙ ХӨГЖИЛ

Говь ХК нь тогтвортой хөгжлийн үйл ажиллагааг бизнесийн үйл ажиллагаанд нэгтгэн тасралтгүй хөгжүүлэх үүрэг амлалтыг өгсөн бөгөөд 2023 онд энэхүү амлалтын хүрээнд тогтвортой хөгжлийн удирдлагын дараах ажлуудыг хийж гүйцэтгэв. Үүнд:

- Монголын Хөрөнгийн Биржид 2022 оны БОНЗ-ын тайланг хүргүүлсэн.
- Traceability index боловсруулан танилцуулсан.
- Сав баглаа боодлын шинэчлэл төслийг санаачлан хэрэгжүүлж маркетингийн багуудад хүлээлгэн өгсөн.
- Тогтвортой хөгжлийн тайланг монгол, англи хэлээр бэлтгэн олон нийтэд хүргэсэн.
- Хамтран ажиллагч байгууллагуудтай харилцаа холбоогоо өргөжүүлэн ажилласан.
- Тогтвортой хөгжлийн бодлогын зорилтыг хэрэгжүүлэх хөтөлбөрүүдийг батлуулсан.
- ADB, CNN, ToC, UNDP, EU гэх мэт олон улсын байгууллагуудын гаднын зочид төлөөлөгчдийг хүлээн авч уулзан, үйлдвэр танилцуулах аяллыг зохион байгуулсан.
- Тогтвортой хөгжлийн аудитыг Азийн Хөгжлийн Банкаар хийлгэсэн. Тус аудитын үр дүнд суурилсан залруулах ажиллагааны төлөвлөгөөг хэрэгжүүлэн ажиллаж байна.
- НҮБ-ын Аж үйлдвэр хөгжлийн байгууллага, ХХААХҮЯ хамтран хэрэгжүүлж буй экспортыг дэмжих төсөлд Говь ХК оролцож, ОЕКО made in green сертификатчлалыг дэмжих төсөлд хамрагдан ажиллаж байна.
- Говь ХК-н тогтвортой хөгжлийн тухай монгол, англи хэл дээрх вэб хөгжүүлэлтийн ажил хийгдэж байна.
- Хамтран ажиллагч байгууллагуудтай харилцаа холбоогоо өргөжүүлэн ажиллаж байгаа бөгөөд үүний хүрээнд Тогтвортой ноос, ноолуурын эвслийн гишүүнчлэлийн уулзалтыг зохион байгуулав.
- Бүтээгдэхүүний байгаль орчинд үзүүлэх нөлөөлөл, хэрэглэгчдийг төөрөгдлөөс хамгаалах тухай Европын холбооны улс орнуудад нэвтэрч буй хууль, түүний үе шат, хэрэгжилтийн талаар компанийн удирдлагуудад танилцуулав.

Тогтвортой ноолуур, гурван талт төсөл

Хөдөө аж ахуйн их сургууль, малчид болон Говь ХК хамтран “Тогтвортой ноолуур, гурван талт хамтарсан төсөл”-ийг 4 дөх жилдээ амжилттай хэрэгжүүлж байна. Тус төслийн хүрээнд 2023 онд хийгдсэн ажлаас дурдвал:

- Тогтвортой ноолуур, гурван талт хамтарсан төслийн хүрээнд төслийн малчдаас ноолуур худалдан авч эхэлсэн.
- Төслийн менежментэд шинэчлэл хийж, мал үржлийн ажлын хариуцагчийг солих шийдвэрийг гаргасан.
- Баянхонгор аймгийн Жинст сум, Хөвсгөл аймгийн Их-Уул сумуудад нийт 22 айлын хашаа хороо, 11,403 малыг тусгай тоноглолтой явуулын угаалгын машин ашиглан угаалга, ариутгал, халдваргүйжүүлэлт хийв.
- Төслийн хүрээнд худалдан авсан ноолуураар хийх бүтээгдэхүүн хөгжүүлэлтийг шийдвэрийг төслийн баг гаргасан.
- Ноолуур бэлтгэлийн зохистой дадал сургалтын видео хийн, төслийн сумдад илгээсэн.
- Төслийн хэрэгжилтийн тухай баримтат видео хийгдэж байна.
- Төсөлд хамрагдсан малчдын ямаанаас авсан дээжийн 2023 оны шинжилгээгээр ноолуурын голч, хагт хольц өнгөрсөн жилийн үзүүлэлтээс буурсан үр дүн гарсан.

Нэгдсэн удирдлагын тогтолцоо

- SFA "Тогтвортой арга аргачлалаар цэвэр ноолуур боловсруулах зохистой дадал" үнэлгээний аудитад амжилттай оролцсон.
- ISO 9001:2015 Чанарын удирдлагын тогтолцооны стандартын баталгаажуулалтын аудитад амжилттай хамрагдан 6-р сард гэрчилгээгээ гардан авсан. Мөн 2022 онд баталгаажуулалтаа авсан ISO 14001:2015, ISO 45001:2018 стандартуудын магадлан аудитад амжилттай хамрагдаж гэрчилгээгээ сунгаж чадсан. Ингэснээр Говь ХК нь нэгдсэн удирдлагын тогтолцоог албан ёсоор хэрэгжүүлэгч компани болж чадлаа.



- Байгууллагын хэмжээнд нийт 20 ажилтан НУТ-ны ISO 9001, ISO 45001, ISO 14001 болон ISO 50001 стандартуудын хүрээнд ISO 19011 стандартын аргачлалын дагуу дотоод аудит хийх арга зүйд суралцаж, дотоод аудиторын эрхээ баталгаажуулж гэрчилгээ гардан авав.

Комплаенсын удирдлага

- Комплаенсын удирдлагын хүрээнд 2022 онд компанийн хэмжээнд шүгэл үлээх системийг хэрэгжүүлж эхэлсэн бол энэ онд шүгэл үлээх тогтолцооны үйл ажиллагаа хэвийн явагдаж байгаа бөгөөд 2023 оны эхний хагасын байдлаар нийт 39 зөрчлийг шийдвэрлэсэн байна.
- Байгууллагын ёс зүйн сургалтын хэрэгцээг тодорхойлох асуулгыг авсны үр дүнд сургалтын материал боловсруулж сургалтын төлөвлөгөө гарган ажиллаж байна.
- Дүрэм журам, баримт бичгийн хүрээнд 3-р улиралд Шүгэл үлээх тогтолцооны үйл ажиллагааны журмыг шинэчлэн боловсруулж ТУЗ-өөр батлуулсан. Мөн Ёс зүйн кодын хэрэгжилтийг зохицуулах журмыг шинээр боловсруулан Гүйцэтгэх захирлын тушаалаар батлуулсан.
- Сургалт хөгжлийн хүрээнд Ёс зүйн хорооны гишүүд болон нийцлийн менежер, ТУЗ-ийн ажлын албаны ажилтнууд нь дараах сургалт, хэлэлцүүлэгт оролцсон. Үүнд:
 - Бизнесийн ёс зүй, комплаенсын үндэсний II форум,
 - “Комплаенс ба эрсдэлийн удирдлага” сэдэвт сургалт,
 - Бизнесийн Ёс зүйн төв болон Ти Монгол ТББ хамтран зохион байгуулсан Бэнчмарк хөтөлбөр,
 - Рио Тинто Монгол ХХК-ийн дэмжлэгээр МУХАҮТ-ийн Бизнесийн ёс зүйн төв болон Эрдэс Баялаг эмэгтэйчүүдийн холбоо ТББ-тай хамтран "Ёс зүйтэй, Тогтвортой өсөлт" сургалт хэлэлцүүлэг,
 - Японы Засгийн газрын дэмжлэгтэйгээр НҮБ-ээс зохион байгуулсан Хариуцлагатай бизнес ба хүний эрхийн магадлан шинжилгээний сургалт.

Эрсдэлийн удирдлага

- Эрсдэлийн удирдлагын бодлогыг 2023 оны 2 сарын 3-нд, Эрсдэлийн удирдлагыг хэрэгжүүлэх журмыг 2023 оны 5 сарын 15-нд тус тус шинэчлэн батлуулсан.
- Нийт ажилтнуудад Эрсдэл тохиолдох магадлал бий болсон нөхцөлд хэрхэн мэдэгдэх зөвлөмжийг бэлтгэн компанийн дотоод сүлжээнд байршуулсан.
- Ахисан түвшинд буюу удирдлагын түвшинд Эрсдэлийн удирдлагын менежментийг хэрхэн үр дүнтэйгээр хэрэгжүүлэх аргазүйн сургалтыг нийт 11 газрын 41 хэлтсийн болон 5 үйлдвэр, 28 албаны дарга нарт орсон.
- Эрсдэлийн мониторингийн үр дүнд нийт 551 эрсдэлээс 44 эрсдэл бүрэн хаагдаж, эрсдэлийн дундаж түвшин 2023 оны 1-р улирлаар 7 оноотой байсан бол 3-р улирлаар 3 оноотой буюу БАГА түвшинд болж буурсан.

ХӨДӨЛМӨРИЙН ЭРҮҮЛ МЭНД АЮУЛГҮЙ БАЙДАЛ



Эрүүл мэндийн хугацаат үзлэг-2023

“Хужиртсод” ХХК-тай хамтран 2023.05.16-наас 2023.09.08-ны хооронд бүх ажилтны эрүүл мэндийн хугацаат үзлэг зохион байгуулсан бөгөөд нийт 1,540 ажилтан хамрагдав.



Ундны усны шинжилгээ хийлгэв

Ундны усны MNS 0900:2018 стандартад заасан нян судлалын 3-4 үзүүлэлтийг, жилдээ 1 удаа сорьцод шинжилгээ хийж хяналт тавин ажиллах ажлын хүрээнд компанийн ундны усны 68 цэвэршүүлэгч цэгт нян судлалын шинжилгээ хийсэн.



Байгууллагын эмнэлэг

Говь ХК нь үйлдвэрийн барилга дотроо байгууллагын дэргэдэх эмнэлэгтэй бөгөөд ажилтнууддаа эрүүл мэндийн анхан шатны тусламж үйлчилгээг цаг алдалгүй хүргэх боломжоор хангагдсан байдаг. Мөн тус эмнэлгээрээ дамжуулан европ болон дорнын анагаах ухааны үйлчилгээг нийт ажилтнууддаа үнэ төлбөргүй үзүүлдэг. 2023 оны 3-р улирлын байдлаар эмчийн өдөр тутмын үзлэгт 2,792 ажилтан, сувилахуйн тусламж үйлчилгээнд 3,306 ажилтан хамрагдав.



Гамшгаас хамгаалах сургалт

2023.09.29-ний өдөр ХУД-ын Онцгой байдлын хэлтэс, Гал унтраах 014 ангитай хамтран “Гамшгаас хамгаалах практик” сургалтыг 200 ажилтныг хамруулж амжилттай зохион байгуулсан.



Гамшгийн үеийн бэлэн байдал

Гамшгийн үед яаралтай тусламж үзүүлэх бэлэн байдлыг хангах зорилгоор Дунд шатны Улаан загалмайн хороо (ДШУЗХ)-д гамшгийн үеийн тусламж тараалт, анхны тусламж, ус ба эрүүл ахуй, нийгэм сэтгэл зүйн дэмжлэг үзүүлэх чиглэлээр мэргэшсэн баг бэлтгэх сайн дурын гамшигтай тэмцэх баг бэлтгэх сургалтыг зохион байгуулж, ДШУЗХ-ны гамшгийн хариу арга хэмжээ авах хүчин чадавхыг нэмэгдүүлэх зорилгоор Говь ХК мэргэшсэн багыг бүрдүүлэн ажиллав.



Дархлаажуулалт

Үйлдвэрийн ажилтнуудын дархлааг дэмжих, томуу томуу төст өвчнөөс урьдчилан сэргийлэх зорилгоор Ази Фарм ХХК-тай хамтран Витамины өдөрлөгийг амжилттай зохион байгууллаа. Мөн үйлдвэрийн ажилтнуудад дархлаа дэмжих витамин багцыг уух заавар болон зөвлөгөөний хамт тараан өгөв.

БАЙГАЛЬ ОРЧИН



“Тэрбум мод” үндэсний хөдөлгөөн

Эко зулзаган төгөл ХХК-тай хамтран Хан-Уул дүүргийн 21-р хороо, Айцын аманд 200 ширхэг мод тарих ажлыг технологийн дагуу тарьж ХУД-ийн Ногоон байгууламжийн хэлтэст талбайг хүлээлгэн өгсөн.



Гадна талбайн зүлэгжүүлэлт

Байгууллагын нийт талбайн 10%-ийг ногоон байгууламж болгох зорилгын хүрээнд 500 ширхэг цэцгийн мандал, 307 ширхэг бут суулгахаас гадна 966 м2 талбайд нөхөн тарилт, зүлэгжүүлэлтийн ажил хийгдсэн.



Химийн бодис

Химийн бодистой харьцан ажилладаг ажилтнуудыг чадавхжуулах, зохистой хэрэглээний мэдлэг ойлголт олгох сургалтыг “МКЛ” ХХК-тай хамтран зохион байгуулав. Мөн химийн бодис хэрэглэдэг бүх газар нэгжүүдэд химийн бодис асгарч алдагдахаас сэргийлэх зориулалтын подонуудыг байршуулав. Ингэснээр химийн бодисын асгаралтын байгаль орчинд үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах юм.



Хог хаягдал зан төлөв, хандлагын судалгаа

Хог хаягдлын менежментийг сайжруулах үүднээс “Өнгө нэм” ТББ-тай хамтран компанийн хэмжээнд Хог хаягдлын судалгаануудыг хийж, үр дүнд нь үндэслэн хог хаягдлын ангиллыг 4 болгож тэмдэглэгээг шинэчлэх, хогийн цэгийг шинээр хийхээр төлөвлөж зураг төсөл хийх, хог хаягдлын менежментийг цаашид сайжруулах тайланг танилцуулах зэрэг ажлуудыг хийсэн.



Орчны хяналт шинжилгээ

Орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийн хүрээнд Агаар, Цэвэр ус, Бохир ус, Хөрсний дээж шинжилгээ, мониторинг хийгдэж, зөвшөөрөгдөх хэмжээнд хэвийн үзүүлэлт хангагдсан.



Эрчим хүч

Сэргээгдэх эрчим хүчийг нэвтрүүлэх зорилгоор байгууллагын үйлдвэрийн дээврийн талбайд Нарын цахилгаан үүсгүүр суурилуулах боломжит хүчин чадлын хэмжээг тооцоолон НҮБ-д төсөл бичиж илгээв. Мөн тус зорилгын хүрээнд байгууллагын боломжит байршлуудад нарны эрчим хүчний системүүдийн загварчлалыг Huawei болон CRD байгууллагуудтай хамтран хийв.

ХҮНИЙ НӨӨЦ

НИЙТ АЖИЛТНУУДЫН ТОО – 1,667



ЗАХИРГАА
252



БОРЛУУЛАЛТ
282



ҮЙЛДВЭР
1,118



ОХИН КОМПАНИ
15

Ажилтнуудын хүйсийн харьцаа

Эрэгтэй
29%

Эмэгтэй
71%

Ажилтнуудын дундаж нас



35

Хүүхэд асрах чөлөөтэй ажилтан

367

Шинээр ажилд орсон ажилтны тоо

749



Бидний уриа

Говь ХК-ийн Хүний нөөцийн газар нь “The Best & Happiest Employee” буюу “Хамгийн шилдэг & Аз жаргалтай ажилтан” гэсэн уриан дор ажилтнууд руугаа чиглэсэн хүний нөөцийн бодлогыг хэрэгжүүлэн ажиллаж байна.

Эмэгтэйчүүдийг дэмжигч байгууллага

Компанийн хэмжээнд 17 захирал, 77 дунд шатны удирдах албан тушаалтан буюу нийт 94 удирдах албан тушаалтан ажилладаг. Үүнээс 74% нь эмэгтэй, 26% нь эрэгтэй албан тушаалтнууд байна.

Нийт эмэгтэй удирдах албан тушаалтнуудын 89% нь ур чадвараа нэмэгдүүлэн ажиллаж буй хугацаандаа албан тушаал дэвшин, олон улсад өрсөлдөх ур чадвараа тасралтгүй нэмэгдүүлэн ажиллаж байна.

Залуучуудыг дэмжигч байгууллага

Нийт ажилтнуудын 56%-ийг 18-35 насны залуу ажилтнууд эзэлж байна. Мөн Европ, ХБНГУ, АНУ, БНХАУ, Их Британи гэх мэт гадаад зах зээлд ажилладаг ажилтнуудын 80% нь GenZ үе буюу залуу үеийн төлөөллүүд ажилладаг бөгөөд олон улсын зах зээлд өрсөлдөх ур чадвартай ажилтнууд Монгол ноолууран хувцсыг дэлхийн хүн бүрт хүргэж байна.

Говийн багачууд цэцэрлэг

Байгууллагын дэргэдэх “Говь-ийн багачууд” цэцэрлэг 2022 онд нээлтээ хийснээс хойш жилийн 4 улирлын турш тасралтгүй үйл ажиллагаагаа явуулж байна. Зуны улиралд ч амралгүйгээр үйл ажиллагаагаа явуулснаар ажилтнууд маань хүүхдүүдээ эрүүл, аюулгүй орчинд сургаж хүмүүжүүлэхээс гадна сэтгэл амар ажиллах боломж бүрдсэн.

Уян хатан ажлын цаг

Замын хөдөлгөөний түгжрэлээс урьдчилан сэргийлэх, ажилтнуудын ажил амралтын цагийг тэнцвэржүүлэх, хүүхэд хамгааллын бодлогыг хэрэгжүүлэх зорилгоор 3 дахь жилдээ ажлын уян хатан цагийн системийг оффисын 500 гаруй ажилтнуудад хэрэгжүүлж байна. Мөн сүлжмэлийн үйлдвэрийн нярай болон цэцэрлэгийн насны хүүхдүүдтэй сүлжмэл бүтээгдэхүүний 24 оёдолчныг богиносгосон цагаар ажиллуулж байна.

СУРГАЛТ ХӨГЖИЛ

2023 оны 3-р улирлын байдлаар компанийн хэмжээнд давхардсан тоогоор нийт 5,953 ажилтанд сургалт орсон. Үүнд:

- Дасан зохицуулах, чиглүүлэх сургалт – 957 хүн;
- Хувь хүний хөгжлийн сургалт – 2,083 хүн;
- Мэргэжлийн сургалт – 668 хүн;
- ХЭМАБ сургалт – 1,639 хүн
- Дотоод сургагч багшийн сургалт – 177 хүн
- Гадаад эх үүсвэрээс авсан сургалт – 429 хүн тус бүр хамрагдсан.



Үйлдвэртэй танилцах аяллууд

79 удаагийн 1,008 гадаад зочид, 84 удаагийн 1,034 дотоодын зочдод үйлдвэртэй танилцах аялал зохион байгуулж 3-р улирлын байдлаар нийт 163 удаагийн үйлдвэр танилцуулах аяллаар 2,042 зочдыг хүлээн авч танилцуулсан.



Гэр бүлийн өдөрлөг - 2023

2023 оны 3-р улирлын байдлаар нийт 66 ажилтны гэр бүлийн гишүүдэд байгууллагын танилцуулга болон сургалт, үйлдвэрийн аялал багтсан “Гэр бүлийн өдөрлөг” амжилттай зохион байгуулагдлаа.



НОВВУ ZONE - Сонирхлын клубүүд

2022 онд нийт ажилтнуудын дунд СОНИРХЛЫН КЛУБ-үүд байгуулагдаж 3-р улирлын байдлаар 12 клубүүдэд 500 гаруй ажилтан хамрагдаж идэвхтэй үйл ажиллагаа явуулж байгаа. 2023 оны 9-р сарын 5-ны өдөр СОНИРХЛЫН КЛУБ нээгдсэний 1 жилийн ой тохиож бүх клубүүд энэхүү үйл ажиллагаанд оролцлоо.



GOBI TRAINER - 2023


Байгууллага дотоод нөөц боломжоо ашиглан дотоодын сургагч 27 багшийг бэлтгэж авлаа. Ингэснээр гаднын байгууллагаас авах сургалтыг өөрийн багш нараар мөн ГОВЬ ХК-ийн соёлыг дотоодын сургагч багш нараар дамжуулан ажилтнууддаа түгээх боломж бүрдэж байна.



Нэгжийн удирдлагыг чадавхжуулах үйл ажиллагаа

2023 оны 8-р сарын 18-нд нийт 77 нэгжийн удирдлагуудад Удирдах ажилтны ур чадвар, багийн хамтын ажиллагаа сэдвийн хүрээнд сургалт судалгааны ПОЛИСИ төвтэй хамтран сургалт зохион байгууллаа.

НИЙГМИЙН ХАРИУЦЛАГА



Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг дэмжигч - Эко давуун тор

Говь ХК-д шинээр орсон ажилтан үндсэн ажилтан болоход “Үндсэн ажилтны өдөрлөг”-ийг зохион байгуулдаг билээ. Уг өдөрлөгөөр шинээр үндсэн ажилтан болж буй ажилтнууддаа гарын бэлгийг гардуулдаг ба үүнд эко давуун тор багтдаг. Бид нийгмийн хариуцлагын хүрээнд хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн “Эко давуун торны үйлдвэр”-ийг дэмжин давуун торыг уг үйлдвэрээс захиалан хийлгэж байна.



Олон улсын хүүхдийн эрхийг хамгаалах өдөр

Олон улсын хүүхдийн эрхийг хамгаалах өдрийг тохиолдуулан "Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн сэргээн засах хөгжлийн төв", Тайванийн хүүхэд, гэр бүлийг дэмжих төв "Гэр Хотхон", "Өнөр альфа" асрамжийн газрын нийт 135 хүүхдүүдэд хүүхдийн баярын бэлэг бэлэглэж бяцхан зүрхэнд баяр баяслыг түгээлээ.



ХУД-ийн Гэр бүл хүүхэд залуучуудын газартай хамтын ажиллагаа

Говь ХК нь гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн үйл ажиллагааг дэмжиж олон талын үйл ажиллагаа зохион байгуулах зорилгоор ХУД-ийн Гэр бүл хүүхэд залуучуудын газартай хамтран ажиллах САНАМЖ БИЧИГ байгуулан ажилтнуудаа сургаж хөгжүүлж байна.



Цусны донорын өдөрлөг

Улаан загалмай цусны төв, үйлдвэрчний эвлэлтэй хамтарсан “Цусаа өгөх өдөрлөг” зохион байгуулж нийт 50 ажилтан цусаа хандивлаж энэхүү үйл ажиллагаанд идэвхтэй хамрагдлаа.

Мэдээлэл гаргагч этгээд болон мэдээллийн үнэн зөвийг баталсан этгээдийн гарын үсэг, огноо:

Овог, нэр: Ц.Баатарсайхан

Овог, нэр:

Албан тушаал: "Говь" ХК-ийн Гүйцэтгэх захирал

Албан тушаал : "... " Аудитын компанийн Гүйцэтгэх захирал

Гарын үсэг:

Гарын үсэг:

(Тамга/тэмдэг)



(Тамга/тэмдэг)

Мэдээлэл бэлтгэж, хүргүүлсэн этгээдийн гарын үсэг, огноо:

Овог, нэр: М.Сэлэнгэ

Албан тушаал: ТУЗ-ийн нарийн бичгийн дарга

Гарын үсэг:

Огноо: 2023.10.18



"ГОВЬ" ХУВЬЦААТ КОМПАНИ БОЛОН
ТҮҮНИЙ ОХИН КОМПАНИУД
НЭГТГЭСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН

2023 оны 09 сарын 30

(мян.төгрөг)

	2023.09.30	2022.12.31
ХӨРӨНГӨ		
Эргэлтийн хөрөнгө		
Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгө	4,760,961	9,034,919
Дансны ба бусад авлага	27,943,754	3,318,986
Урьдчилгаа төлбөр	8,596,833	2,318,495
Бараа материал	163,243,328	128,791,463
Буцаах эрхтэй бараагаарх хөрөнгө	-	17,227
	204,544,877	143,481,090
Эргэлтийн бус хөрөнгө		
Үндсэн хөрөнгө	132,393,349	137,432,575
Ашиглах эрхтэй түрээсийн хөрөнгө	2,321,765	731,724
Хойшлогдсон татварын хөрөнгө	14,587,932	14,879,483
Бусад эргэлтийн бус хөрөнгүүд	1,132,587	1,587,295
	150,435,632	154,631,077
Нийт хөрөнгийн дүн	354,980,509	298,112,167
ӨР ТӨЛБӨР БА ЭЗЭМШИГЧДИЙН ӨМЧ		
Богино хугацаат өр төлбөр		
Дансны ба бусад өглөг	42,024,252	20,969,192
Гэрээний өр төлбөр	2,268,926	1,983,898
Буцаах эрхтэй барааны өр төлбөр	-	26,503
Богино хугацаат түрээсийн өглөг	2,073,657	777,988
Орлогын албан татварын өглөг	1,093,585	3,683,126
Богино хугацаат зээл	182,134,816	129,853,617
	229,595,235	157,294,324
Урт хугацаат өр төлбөр		
Урт хугацаат түрээсийн өглөг	348,141	112,069
Урт хугацаат зээл	80,552,354	95,686,234
Бусад урт хугацаат өглөг	31,114,743	30,984,941
Хойшлогдсон татварын өглөг	8,206,834	8,206,834
	120,222,072	134,990,078
Нийт өр төлбөрийн дүн	349,817,308	292,284,402
Эзэмшигчдийн өмч		
Хувьцаат капитал	780,113	780,113
Дахин үнэлгээний нэмэгдэл	44,568,540	44,568,540
Гадаад валютын хөрвүүлэлтийн нөөц	(8,217,101)	(11,436,010)
Хуримтлагдсан алдагдал	(31,968,350)	(28,084,878)
	5,163,202	5,827,765
Нийт өр төлбөр ба эзэмшигчдийн өмчийн дүн	354,980,509	298,112,167

(мян.төгрөг)

	2023.09.30	2022.12.31
Борлуулалтын орлого	166,375,788	193,427,609
Борлуулсан бүтээгдэхүүний өртөг	(86,583,895)	(97,766,831)
Нийт ашиг	79,791,893	95,660,778
Бусад орлого	418,305	1,162,425
Борлуулалт ба маркетингийн зардал	(44,009,656)	(61,767,484)
Ерөнхий ба удирдлагын зардал	(14,418,200)	(14,138,399)
Санхүүгийн хөрөнгийн үнэ цэнийн бууралтын буцаалт	-	49,464
Бусад зардал	-	(13,355)
Санхүүгийн орлого	216,345	29,261
Санхүүгийн зардал	(24,879,278)	(30,979,282)
Татварын өмнөх алдагдал	(2,880,591)	(9,996,592)
Орлогын татварын өгөөж (зардал)	(1,002,882)	2,998,982
Тайлант жилийн цэвэр алдагдал	(3,883,472)	(6,997,610)
Ашиг, алдагдал руу дараа үед дахин ангилагдах боломжтой бусад дэлгэрэнгүй орлого:		
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээ	-	-
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний татварын нөлөөлөл		(4,301,861)
Гадаад дахь охин компаниудын цэвэр хөрөнгийн гадаад валютын ханшийн хөрвүүлэлтийн зөрүү	3,218,909	(11,997,888)
Тайлант жилийн бусад дэлгэрэнгүй (алдагдал) орлого	3,218,909	(16,299,749)
Тайлант жилийн нийт дэлгэрэнгүй алдагдал	(664,563)	(23,297,359)

	Хувьцаат капитал	Дахин үнэлгээний нөөц	Гадаад валютын хөрвүүлэлтийн нөөц	Хуримтлагдсан ашиг (алдагдал)	Нийт
2022 оны 01 сарын 01-ний үлдэгдэл	780,113	48,870,401	561,878	(21,087,268)	29,125,124
Тайлант жилийн цэвэр алдагдал	-	-	-	(6,997,610)	(6,997,610)
Бусад дэлгэрэнгүй орлого	-	(4,301,861)	(11,997,888)	-	(16,299,749)
Тайлант жилийн нийт дэлгэрэнгүй алдагдал		(4,301,861)	(11,997,888)	(6,997,610)	(23,297,359)
Зарласан ногдол ашиг	-	-	-	-	-
2022 оны 12 сарын 31-ний үлдэгдэл	780,113	44,568,540	(11,436,010)	(28,084,878)	5,827,765
Тайлант жилийн цэвэр алдагдал	-	-	-	(3,883,472)	(3,883,472)
Бусад дэлгэрэнгүй алдагдал		-	3,218,909		3,218,909
Тайлант жилийн нийт дэлгэрэнгүй алдагдал	-	-	3,218,909	(3,883,472)	(664,562)
Зарласан ногдол ашиг	-	-	-	-	-
2023 оны 09 сарын 30-ний үлдэгдэл	780,113	44,568,540	(8,217,101)	(31,968,350)	5,163,202

(мян.төгрөг)

	2023.09.30	2022.12.31
Үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээ	(69,351,109)	45,908,164
Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээ	(3,695,826)	(3,124,091)
Санхүүгийн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээ	65,507,960	(26,140,862)
Бүх цэвэр мөнгөн гүйлгээ	(7,538,975)	16,643,211
Гадаад үйл ажиллагааг хөрвүүлсэн гадаад валютын ханшийн зөрүү	3,218,909	(11,997,888)
Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгийн үлдэгдэл дэх ханшийн зөрүүгийн нөлөөлөл	46,107	117
Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	9,034,919	4,389,479
Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	4,760,961	9,034,919

GOBI

MONGOLIAN CASHMERE

ГОВЬ ХУВЬЦААТ КОМПАНИ ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ДЭРГЭДЭХ ЭРСДЭЛ АУДИТЫН ХОРООНЫ ХУРЛЫН ТОГТООЛ

2023 оны 10 сарын 14 өдөр

Дугаар 05

Улаанбаатар хот

Г 2023 оны 3-р улирлын санхүүгийн
тайланг дүгнэх тухай 7

Санхүүгийн Зохицуулах Хорооноос баталсан “Үнэт цаасны бүртгэлийн журам”, Говь ХК-ийн ТУЗ-ийн дэргэдэх Эрсдэл, аудитын хорооны хурлын шийдвэрийг тус тус үндэслэн Эрсдэл, аудитын хорооны хурлаас **ТОГТООХ нь:**

1. Говь ХК-ийн 2023 оны 3-р улирлын санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд нь үнэн зөв тайлагнагдсан болохыг баталсугай.
2. 3-р улирлын тайланг холбогдох журмын дагуу Санхүүгийн Зохицуулах Хороо, Монголын Хөрөнгийн Бирж-д хүргүүлэн олон нийтэд тайлагнан ажиллахыг ТУЗ-ийн нарийн бичгийн дарга /М.Сэлэнгэ/-д үүрэг болгосугай.

Говь ХК-ийн ТУЗ-ийн дэргэдэх

Эрсдэл, аудитын хорооны дарга

Гишүүд



А.ЖАРГАЛМАА

Д.ГЭРЭЛМАА

Д.ХУЛАН